

МСЗ УРАЛДААНД ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗӨВЛӨГӨӨ

1. Багаараа хамтран ажиллах, хувийн болон бусад бэлтгэлээ хангаж, бие даан ажиллах цаг гаргаарай.
2. Математик загварчлалын талаар анхдагч мэдлэг, ойлголттой болоорой. АНУ-ын ахлах ангийн сурагчдын дундах МЗ уралдааны "**math modeling**" номыг дор хаяж 2-3 цаг зарцуулан нухацтай уншаарай. Google translate ашиглавал илүү хялбар байх болно. 3-р сарын 26-ний өдөр Математик загварчлалын талаарх монгол тайлбартай хичээлүүд mat.mn вэб хуудсанд байршина.
3. Статистикийн талаарх суурь мэдлэг их тус болно. ЕБС-ийн математикийн хичээлийн шинэ цөм хөтөлбөрийн агуулга дахь статистикийн мэдлэг, ойлголтоо ашиглаарай.
4. Бусад ижил төстэй уралдааны сэдэв, багуудын бүтээлүүдтэй танилцаарай. 2013 оны АНУ-ын МЗ уралдааны сэдэв нь зарим талаараа энэхүү МСЗ уралдаантай төстэй. Иймд 2013 оны АНУ-ын МЗ уралдаанд шалгарсан багуудын бүтээлтэй танилцаарай. /Жич: Багууд өөрсдийн бүтээлдээ бусдын бүтээлийг хэсэгчлэн болон бүтнээр нь хуулбарлах, өнгө төрхийг нь өөрчлөн гол санааг нь шууд ашиглах зэргээр хуулбарласан үйлдэл гаргасан тохиолдолд МСЗ тэмцээний дүрмийн дагуу тухайн багийн оноог тэглэх болно.Линк: <https://m3challenge.siam.org/archives/2013/winning-solutions>
5. Дан ганц математик загварчлал, статистикаар хязгаарлагдалгүй математикийн бусад салбаруудыг ашиглаарай.
6. Юуны өмнө асуудлыг тодорхойлоход хэрэг болох статистик өгөгдлүүдийг аль болох их цуглуулаарай.
7. Багийн ажлын төлөвлөгөө, цагийн хувиарлалт гаргаарай. Мөн интернэт, принтер, анги танхимтай холбоотой асуудлуудыг

урьдчилан шийдээрэй. Жижиг асуудлууд цаг их үрж болзошгүйг анхаарна уу.

8. Өдөр бүрийг ашиглаарай. Статистик мэдээлэл цуглуулах ажил хэр байгаа, математикийн аргуудыг ашиглах асуудал ямар шатанд явж байгаа, судалгаа хэр байгаа, асууж тодруулах эсвэл уншиж судлаад учрыг нь олох асуудлууд ямар явцтай байгаа, хариуцсан ажлаа гишүүд хэр зэрэг биелүүлж байгаа гэх мэт асуудлуудад анхаарлаа хандуулж байгаарай.
9. Уралдааны сэдэв, юу хийх гэж байгаа талаар үе үе цаг гарган олон талаас нь бодож эргэцүүлээрэй. Математик загвар боловсруулахад шинэ санаа, онцлог шийдэл тус болно.
10. Тооцооллуудаа анхнаасаа компьютер дээр хийгээрэй. Цаасан дээр санаа гаргах, загварчлах ажлуудыг хийж болох боловч тооцооллыг компьютерт хийх нь цаг хэмнэдэг.
11. Гаргасан тооцоолол, үр дүнгүүдээ математикийн бусад арга, програмуудыг ашиглан шалгаарай.
12. Бүтээлчээр сэтгээрэй. Нээлттэй байгаарай. МСЗ уралдааны комиссоос багуудад өгч буй зөвлөгөө, хичээл, санамжуудаар хязгаарлагдаж болохгүй. Тэдгээр нь та бүхэнд зөвлөн туслах зорилготой юм.
13. Бүтээлээ үг, санааг нуршилгүй, товч бөгөөд тодорхой бичээрэй.
14. Аль болох нээлттэй, чөлөөтэй ажиллаарай. Хугацаандаа амжуулахаа мартуузай!
15. Бүх хүчин чадлаа дайчлаарай. Уралдааны эхний 10 байрт шалгарсан ч бай, үгүй ч бай уралдаанд оролцсоноороо та бүхэн асуудлын шийдлийг олоход туслан, STEM(Science, Tech, Engineering and Math)-ийн мэргэжлээр сурахад нэг алхам ойртож байгаа хэрэг юм. Түүнчлэн гадаадын их сургуульд элсэх, тэтгэлэг

хүсэх өргөдөлд чинь уралдаанд оролцож байсан гэдэг нь давуу тал болно.

16. Уралдаанд оролцоно гэдэг бол шинэ туршлага хуримтлуулан, математикийн мэдлэг болон математикийг амьдралд хэрэглэх чадвараа өсгөж, өсөж хөгжих боломжоо нэмэгдүүлж, өөрийгөө сорьж буй хэрэг юм. Би чадна. Би чадна. Би чадна. Би чадна... Бид багаараа чадна.